

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал.....	9
4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан .....	11
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	19

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

СҮҮЖ-УУЛ АМРАЛТ, СЭРГЭЭН  
ЗАСАХ СУВИЛЛЫН ДАРГА,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА  
Ц.БАТБААТАР ТАНАА

2020.02.27 № 06/628  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүүж-Уул амралт, сэргээн засах сувиллын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Сүүж-Уул амралт, сэргээн засах сувиллын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Сүүж-Уул амралт, сэргээн засах сувиллын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Сүүж-Уул амралт, сэргээн засах сувиллын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг амралт сувиллын дарга, Цагдаагийн хурандаа Ц.Батбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, байгууллагын дотоод хяналтыг сайжруулж ажиллах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүүж-Уул амралт, сэргээн засах сувиллын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүүж-Уул амралт, сэргээн засах сувиллын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 1 дүгээр сарын 28-наас 2020 оны 2 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Шинэ их тэрбум аудит” ХХК-ийн аудитор Д.Тогтохбаяр, аудиторын туслах Д.Мөнгөнтуяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Сүүж-Уул амралт, сэргээн засах сувиллын 2019 оны төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр 67/06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Нийгмийг аюулаас хамгаалах яамны “Сүүжийн уул” нэртэй амралтыг 1982 онд анх байгуулсан. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны А/188 дугаар тушаалаар амралт сувиллын чиглэлээр үйл ажиллагаа явуулах Сүүж-Уул амралт, сэргээн засах сувиллыг шинэчлэн зохион байгуулж ажиллуулсан.

Сүүж-Уул амралт, сэргээн засах сувиллын үйл ажиллагааны эрхэм зорилго нь цагдаагийн албаны ажилтнууд, энгийн амрагч нарт амралт, сэргээн засах эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд оршино.

Сүүж-Уул амралт, сэргээн засах сувиллын үйл ажиллагааны чиглэл нь дараах байдлаар тодорхойлогдоно. Үүнд:

- Сувилал
- Зочид буудал

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны 74 дүгээр тушаалаар Сүүж-Уул амралт, сэргээн засах сувиллын салбар амралтын газрыг Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын нутаг дэвсгэр Хатгал тосгонд байгуулсан, салбар одоогоор үйл ажиллагаа явуулж эхлээгүй байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид шагнал, мөнгөн урамшуулал олгох журам”

#### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэж байна.

Сүүж-Уул амралт, сэргээн засах сувилал нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Acolous программ хангамж ашигладаг байна.

Байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

#### **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Сүүж-Уул амралт, сэргээн засах сувиллын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 12 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,318,393.0 мянган төгрөгөөс тооцон 26,367.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг үйл ажиллагааны цар хүрээтэй холбоотой чанарын нөлөөлөл гараагүй тул өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Сүүж-Уул амралт, сэргээн засах сувиллын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 54,956.2 мянган төгрөгөөр буюу 1.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материал, үндсэн хөрөнгийн дансууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	190.1	-	(190.1)
Урьдчилгаа	5,393.4	2,795.6	(2.597.8)
Бараа материал	371,565.3	427,001.2	55.435.9
Үндсэн хөрөнгө	3,789,283.9	3,681,679.6	(107.604.3)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>4,166,432.6</b>	<b>4,111,476.4</b>	<b>(54.956.2)</b>
Өр төлбөр	16,165.1	-	(16.165.1)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	4,150,267.5	4,111,476.4	(38.791.1)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>4,166,432.6</b>	<b>4,111,476.4</b>	<b>(54.956.2)</b>

Бараа материал өссөн нь хүнс, барилгын материал, хангамжийн материалын үлдэгдэл нөөц өссөнтэй холбоотой. Оны эцэст хэрэгцээ шаардлага хангахгүй болсон, хуучирсан, гологдол бараа материал байгаагүй.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл буурсан нь үндсэн хөрөнгийн элэгдэл байгуулсан, зарим эд хөрөнгийг холбогдох байгууллагын зөвшөөрлийн дагуу акталж данснаас хассан, үнийн зөрүү залруулснаас шалтгаалжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга 332,552.3 мянган төгрөг нь үндсэн хөрөнгийн бүртгэлийн зөрүүг арилгаж, залруулга хийсэнтэй холбоотой.

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Сүүж-Уул амралт, сэргээн засах сувилал тайлант онд 354,667.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлэх төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 417,797.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 117.8 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төсвийн санхүүжилт ба өөрийн орлого

Орлогын төрөл	/мянган төгрөг/			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Улсын төсвөөс санхүүжих	573,395.3	565,225.8	8,169.5	98.6
Эрүүл мэндийн даатгалын сангаас	170,500.0	108,570.0	61,930.0	63.7
Амралт сувиллын үйлчилгээнээс	354,667.0	417,797.7	(63,130.7)	117.8
<b>Нийт дүн</b>	<b>1,098,562.3</b>	<b>1,091,593.6</b>	<b>6,968.7</b>	<b>99.4</b>

Эрүүл мэндийн даатгалын сангаас төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө 63.7 хувийн биелэлттэй гарсан нь үйлчлүүлэгч даатгалтай иргэдийн тоо буурсан. Энэ нь орон нутгийн замын засварын ажлаас шалтгаалан даатгалтай үйлчлүүлэгчдийн тоо буурснаас шалтгаалжээ.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх амралт, сувиллын хөтөлбөрт зориулан 1,098,562.3 мянган төгрөгийн төсөв батлагдаж, урсгал зардалд зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн төвлөрүүлэн захирагчаас Сүүж-Уул амралт, сэргээн засах сувиллын 2019 оны төсөвт зардалд зохицуулалт хийж, зардлыг нэмэгдүүлэх шийдвэрийг гаргасан байна. Төсвийн зарцуулалтыг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад гэрэл цахилгааны зардал 42,287.9 мянган төгрөгөөр, хоол хүнсний зардал 32,929.9 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

**2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 12 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл нэмж тодорхойлон, нийт 13 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 9,861.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 1,239.6 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 8,622.0 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 1,239.6 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

- Зочин төлөөлөгчдийн хоол хүнсний зардалд 1,239.6 мянган төгрөгийн зориулалт бус зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн “6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;” 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасантай нийцэхгүй, мөн үнэн зөв байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулж, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар албан шаардлага хүргүүлэх;

Аудитаар илэрсэн бусад алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.



## **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Цаг хугацааны хувьд хязгаарлагдмал байснаас шалтгаалан эд хөрөнгийн тооллогын бүртгэлд хяналт тавиагүй, мөн туслах аж ахуйн мал сүргийн нас дэвшилт, зах зээлийн үнэлгээ, ашиг шимийн тооцоог бүрэн хянаж амжаагүй тул дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай гэж үзсэн. Анхаарал татахуйц асуудал гараагүй.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Сүүж-Уул амралт, сэргээн засах сувилал нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 19 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. 5.0 сая төгрөгнөөс дээш үнийн дүнтэй нийт 189 гүйлгээг бүртгэж, шилэн дансанд мэдээлсэн байна.

## **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх жилд Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар түүвэрт хамрагдсан ба акт, албан шаардлага, зөвлөмж өгөөгүй байна.

## **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Сүүж-Уул амралт, сэргээн засах сувиллын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБООУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Бид Сүүж-Уул амралт, сэргээн засах сувиллын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНБООУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### **3. Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 Галын аюулд өртсөн автомашины сэлбэгтэй холбоотой асуудал**

3.1.1 Илрүүлэлт: Сүүж-Уул амралт, сэргээн засах сувиллын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй “УАЗ фургон 2206” маркийн автомашин 2018 оны 9 дүгээр сард галын аюулд өртөж, ажил үүрэг гүйцэтгэх боломжгүй болсон байна. Үндсэн хөрөнгийн тооллогоор тус автомашиныг бэлэн байгаа гэж тоолсон. Автомашин нь 2010 оны 3 дугаар сард ашиглалтанд орсон бөгөөд байгуулсан элэгдлээрээ анхны өртгөө нөхөж үлдэх өртөггүй болсон. Ард даатгал компаниас 8,622.0 мянган төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, автоамшиныг засварлах ажилд зориулан 20 нэр төрлийн сэлбэг худалдан авсан боловч данс бүртгэлд тусгаагүй байна. Энэ нь толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйл 14.4.1 “аж ахуйн бүх ажил, гүйлгээг заавал бүртгэнэ” гэсэн заалтыг зөрчсөн.

3.1.2 Эрсдэл: Худалдан авсан сэлбэгийг данс бүртгэлд тусгаагүйгээс дутагдал, шамшигдал гарах эрсдэлтэй.

3.1.3 Өгсөн зөвлөмж: Сэлбэгийг бүртгэлд тусгаж, тайлагнаж байх;

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Тус автомашиныг 2019 оны жилийн эцсийн тооллогоор актлуулах саналаа Санхүү аж ахуйн албанд хүргүүлсэн. Цаашид өгөгдсөн зөвлөмжийг мөрдөж ажиллана.

#### **3.2 Шатахуун зарцуулалтын норм, тооцоотой холбоотой асуудал**

3.2.1 Илрүүлэлт: Амралт сувиллын захиргаа албан үүрэг гүйцэтгэж байгаа автомашины жолооч нарт явах км-т нь тохируулан Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 дүгээр тушаалаар баталсан нормоор тооцож, шатахуун олгож зарлага болгодог. Тайлант хугацааны эцэст шатахууны зарцуулалтын тооцоог бодоогүй байна. Энэ нь толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй

батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4 “*үнэн зөв байх*” заалтыг зөрчсөн.

- 3.2.2 Эрсдэл: Шатахууныг нормоос илүү зарцуулах, үргүй зардал гарах эрсдэлтэй.
- 3.2.3 Өгсөн зөвлөмж: Автомашины замын хуудас, түүний дагалдах хуудсыг бүрэн хөтөлж, шатахуун зарцуулалтын гүйцэтгэлийн тооцоо хийж, актаар баталгаажуулж байх;
- 3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 12-р сарын 30-ны өдрийн батлагдсан нормыг 2020 оны 1-р сарын 1-нээс хэрэгжүүлж ажиллахаар төлөвлөсөн. Цаашид өгөгдсөн зөвлөмжийг мөрдөж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан амралт сувиллын газрын ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>377,148,787.27</u></b>	<b><u>429,796,815.72</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	190,111.00	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	190,111.00	
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	5,393,380.72	2,795,625.22
<b>3471</b>	<b>Урьдчилгаа тооцоо</b>	5,393,380.72	2,795,625.22
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа	5,393,380.72	2,795,625.22
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	371,565,295.55	427,001,190.50
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	7,146,946.00	6,761,207.00
35110	Тусгай зориулалттай материал	4,125.00	4,125.00
35130	Эм боох материал	7,142,821.00	6,757,082.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	4,176,100.00	6,262,015.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	332,677,449.55	355,024,025.50
35410	Бичиг хэргийн материал	4,493,965.00	4,625,885.00
35420	Аж ахуйн материал	49,770,070.20	58,622,540.00
35430	Сэлбэг хэрэгсэл	6,299,850.00	5,066,300.00
35440	Түлш, шатах тослох материал	2,439,901.50	9,587,128.50
35450	Барилгын засварын материал	82,120,108.60	95,718,914.60
35460	Хүнсний материал	5,667,735.29	15,461,971.50
35470	Бусад хангамжийн материал	181,885,818.96	165,941,285.90
35600	Мал амьтад	27,564,800.00	58,953,943.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>3,789,283,858.86</u></b>	<b><u>3,681,679,612.07</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	3,789,283,858.86	3,681,679,612.07
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	3,754,083,858.86	3,646,255,112.07
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,559,575,149.95	3,559,575,149.95
39202	Хуримтлагдсан элэгдэл	14,200,403.45	154,604,533.49
39203	Авто-тээврийн хэрэгсэл	118,080,000.00	68,763,333.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	100,580,000.02	56,866,666.74
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	335,972,025.30	195,206,753.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	282,120,760.16	95,418,461.53
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	166,018,905.28	77,222,150.19
39208	Хуримтлагдсан элэгдэл	128,902,611.00	36,530,763.43
39214	Бусад үндсэн хөрөнгө	155,222,255.00	140,103,212.60
39215	Хуримтлагдсан элэгдэл	54,980,702.04	51,195,061.48
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	35,200,000.00	35,424,500.00
39301	Програм хангамж	985,000.00	224,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	985,000.00	
39303	Бусад биет бус хөрөнгө	35,200,000.00	35,200,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>4,166,432,646.13</u></b>	<b><u>4,111,476,427.79</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>16,165,126.00</u></b>	<b><u>-</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	16,165,126.00	-
<b>413</b>	<b>Өглөг</b>	11,017,126.00	-

41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	11,017,126.00	
<b>414</b>	<b>Урьдчилж орсон орлого</b>	5,148,000.00	-
41440	Бусад урьдчилж орсон орлого	5,148,000.00	
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>4,150,267,520.13</u></b>	<b><u>4,111,476,427.79</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	4,150,267,520.13	4,111,476,427.79
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	895,337,410.65	895,337,410.65
51101	Өмч: - төрийн	895,337,410.65	895,337,410.65
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	184,033,183.00	145,242,090.66
51210	Өмнөх үеийн үр дүн	184,033,183.00	184,033,183.00
51220	Тайлант үеийн үр дүн		(38,791,092.34)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,070,896,926.48	3,070,896,926.48
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>4,166,432,646.13</u></b>	<b><u>4,111,476,427.79</u></b>

## 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,357,369,830.91</b>	<b>1,279,601,937.70</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>501,700,430.91</b>	<b>597,636,637.70</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	501,700,430.91	597,636,637.70
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	373,431,796.92	550,940,208.70
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	324,513,801.00	422,945,739.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	162,898.00	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	48,755,097.92	127,994,469.70
120009	Бусад орлого	128,268,633.99	46,696,429.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>855,669,400.00</b>	<b>681,965,300.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	751,059,400.00	573,395,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	751,059,400.00	573,395,300.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	104,610,000.00	108,570,000.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	104,610,000.00	108,570,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,171,101,282.61</b>	<b>1,318,393,030.04</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,171,101,282.61</b>	<b>1,318,393,030.04</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,169,615,198.61	1,306,933,564.54
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	420,607,655.00	461,265,012.50
210101	Үндсэн цалин	257,476,905.00	297,273,637.00
210102	Нэмэгдэл	163,130,750.00	163,991,375.50
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	34,905,607.00	33,785,172.00
210201	Тэтгэврийн даатгал	22,041,489.00	20,287,961.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,740,779.00	2,468,973.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,144,621.00	1,957,286.00
210204	Ажилгүйдлийн даатгал	455,587.00	400,618.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,523,131.00	8,670,334.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	190,599,546.40	214,610,616.00
210301	Гэрэл, цахилгаан	158,551,491.00	208,468,066.00
210302	Түлш, халаалт	32,048,055.40	6,142,550.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	80,392,504.87	103,613,303.76
210401	Бичиг хэрэг	2,203,520.00	5,081,680.00
210402	Тээвэр, шатахуун	36,665,180.57	39,056,402.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,214,500.00	1,895,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,151,500.00	2,036,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,159,813.30	29,959,734.20
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	6,034,110.00	2,836,400.00
210408	Бараа материал акталсны зардал	13,963,881.00	22,748,087.06
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	145,864,930.64	153,008,715.79

Сүүж-Уул амралт, сэргээн засах сувиллын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,197,281.00	6,130,639.00
210502	Хоол, хүнс	141,028,149.64	146,878,076.79
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,639,500.00	
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>177,451,787.40</b>	<b>106,915,174.00</b>
210604	Урсгал засвар	177,451,787.40	106,915,174.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>240,000.00</b>	<b>1,710,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	240,000.00	1,710,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>611,800.00</b>	<b>7,278,900.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		6,006,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	561,800.00	1,222,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	50,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>118,941,367.30</b>	<b>224,746,670.49</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,459,149.00	31,062,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		300,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	103,482,218.30	193,383,870.49
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,486,084.00</b>	<b>11,459,465.50</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,470,000.00</b>	<b>3,290,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,470,000.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		3,290,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>16,084.00</b>	<b>8,169,465.50</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,084.00	8,169,465.50
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>186,268,548.30</u></b>	<b><u>(38,791,092.34)</u></b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>908,814,688.13</b>	<b>-</b>
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	908,814,688.13	
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>912,275,088.13</b>	<b>-</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	908,814,688.13	
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	3,460,400.00	
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(3,460,400.00)</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>182,808,148.30</u></b>	<b><u>(38,791,092.34)</u></b>

### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>1,186,273,385.00</u></b>	<b><u>1,099,763,039.00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>330,603,985.00</b>	<b>417,797,739.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	330,603,985.00	417,797,739.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	330,603,985.00	417,797,739.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	330,603,985.00	417,797,739.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>855,669,400.00</b>	<b>681,965,300.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	751,059,400.00	573,395,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	751,059,400.00	573,395,300.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	104,610,000.00	108,570,000.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	104,610,000.00	108,570,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>1,186,273,385.00</u></b>	<b><u>1,078,663,039.00</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,186,273,385.00</b>	<b>1,078,663,039.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,184,787,301.00</b>	<b>1,067,203,573.50</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	430,874,651.00	467,189,100.00
210101	Үндсэн цалин	314,992,400.00	390,688,607.39
210102	Нэмэгдэл	115,882,251.00	76,500,492.61
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	31,885,000.00	27,670,973.50
210201	Тэтгэврийн даатгал	25,129,589.00	1,932,300.00
210202	Тэтгэмжийн даатгал		227,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		181,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал		45,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,755,411.00	25,283,873.50
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	170,960,400.00	210,551,700.00
210301	Гэрэл, цахилгаан	165,461,000.00	207,748,900.00
210302	Түлш, халаалт	5,499,400.00	2,802,800.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	59,202,550.00	70,207,600.00
210401	Бичиг хэрэг	2,456,000.00	2,837,700.00
210402	Тээвэр, шатахуун	42,403,000.00	42,403,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,247,500.00	2,302,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,041,500.00	4,718,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,054,550.00	17,946,800.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	134,552,400.00	161,765,300.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,350,000.00	3,062,800.00
210502	Хоол, хүнс	109,722,300.00	142,652,250.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	21,480,100.00	16,050,250.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	356,460,500.00	119,800,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,704,000.00	
210604	Урсгал засвар	347,756,500.00	119,800,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	240,000.00	1,710,000.00



210702	Дотоод албан томилолт	240,000.00	1,710,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	611,800.00	8,008,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		6,736,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	561,800.00	1,222,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	50,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	300,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		300,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,486,084.00</b>	<b>11,459,465.50</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,470,000.00	3,290,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,470,000.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		3,290,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	16,084.00	8,169,465.50
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,084.00	8,169,465.50
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	=	<b><u>21,100,000.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	-	<b>21,100,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>21,100,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	21,100,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		21,100,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	=	<b><u>(21,100,000.00)</u></b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	00.00

#### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>860,137,410.65</b>	<b>1,221,505,817.70</b>	<b>8,088,489.77</b>	<b>2,089,731,718.12</b>
Дахин үнэлгээний нэмэгдэл		1,849,391,108.78		1,849,391,108.78
Тайлант үеийн үр дүн	35,200,000.00		175,944,693.23	211,144,693.23
<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>895,337,410.65</b>	<b>3,070,896,926.48</b>	<b>184,033,183.00</b>	<b>4,150,267,520.13</b>
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	895,337,410.65	3,070,896,926.48	184,033,183.00	4,150,267,520.13
Тайлант үеийн үр дүн			-38,791,092.34	-38,791,092.34
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>895,337,410.65</b>	<b>3,070,896,926.48</b>	<b>145,242,090.66</b>	<b>4,111,476,427.79</b>

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,098,562,300.00	1,091,593,573.50	6,968,726.50	99.4
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,098,562,300.00	1,091,593,573.50	6,968,726.50	99.4
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,095,272,300.00	1,088,303,573.50	6,968,726.50	99.4
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	467,189,100.00	467,189,100.00	-	100.0
Үндсэн цалин	365,592,400.00	390,688,607.39	(25,096,207.39)	106.9
Нэмэгдэл	101,596,700.00	76,500,492.61	25,096,207.39	75.3
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	34,639,700.00	27,670,973.50	6,968,726.50	79.9
Тэтгэврийн даатгал	1,932,300.00	1,932,300.00	-	100.0
Тэтгэмжийн даатгал	227,400.00	227,400.00	-	100.0
ҮОМШӨ-ний даатгал	181,900.00	181,900.00	-	100.0
Ажилгүйдлийн даатгал	45,500.00	45,500.00	-	100.0
Эрүүл мэндийн даатгал	32,252,600.00	25,283,873.50	6,968,726.50	78.4
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	210,551,700.00	210,551,700.00	-	100.0
Гэрэл, цахилгаан	205,987,700.00	207,748,900.00	(1,761,200.00)	100.9
Түлш, халаалт	3,000,000.00	2,802,800.00	197,200.00	93.4
Цэвэр, бохир ус	1,564,000.00		1,564,000.00	0.0
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	70,207,600.00	70,207,600.00	-	100.0
Бичиг хэрэг	2,456,000.00	2,837,700.00	(381,700.00)	115.5
Тээвэр, шатахуун	42,403,000.00	42,403,000.00	-	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,293,000.00	2,302,000.00	991,000.00	69.9
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,055,600.00	4,718,100.00	337,500.00	93.3
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,000,000.00	17,946,800.00	(946,800.00)	105.6
<b>Нормативт зардал</b>	161,765,300.00	161,765,300.00	-	100.0
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,350,000.00	3,062,800.00	287,200.00	91.4
Хоол, хүнс	141,915,300.00	142,652,250.00	(736,950.00)	100.5
Нормын хувцас, зөөлөн эдлэл	16,500,000.00	16,050,250.00	449,750.00	97.3
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	140,900,000.00	140,900,000.00	-	100.0
Багаж, техник, хэрэгсэл	21,100,000.00	21,100,000.00	-	100.0
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,000,000.00		1,000,000.00	0.0
Урсгал засвар	118,800,000.00	119,800,000.00	(1,000,000.00)	100.8
<b>Томилолт, зочны зардал</b>	1,710,000.00	1,710,000.00	-	100.0
Дотоод албан томилолт	1,710,000.00	1,710,000.00	-	100.0
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	8,008,900.00	8,008,900.00	-	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	6,736,600.00	6,736,600.00	-	100.0

үйлчилгээний төлбөр хураамж				
Тээврийн хэрэгслийн татвар	1,222,300.00	1,222,300.00	-	100.0
Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	50,000.00	-	100.0
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	300,000.00	300,000.00	-	100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	300,000.00	300,000.00	-	100.0
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	3,290,000.00	3,290,000.00	-	100.0
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	3,290,000.00	3,290,000.00	-	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,290,000.00	3,290,000.00	-	100.0
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,098,562,300.00	1,091,593,573.50	6,968,726.50	99.4
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	573,395,300.00	565,225,834.50	8,169,465.50	98.6
Улсын төсвөөс санхүүжих	573,395,300.00	565,225,834.50	8,169,465.50	98.6
<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	170,500,000.00	108,570,000.00	61,930,000.00	63.7
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	170,500,000.00	108,570,000.00	61,930,000.00	63.7
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	354,667,000.00	417,797,739.00	(63,130,739.00)	117.8
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	354,667,000.00	417,797,739.00	(63,130,739.00)	117.8
<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	53.00	53.00	-	100.0
Удирдах ажилтан	1	1	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	18	18	-	100.0
Үйлчлэх ажилтан	34	34	-	100.0
<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>53</b>	<b>52</b>	<b>1</b>	<b>98.1</b>
Төрийн тусгай албан хаагч (ТТ)	18	17	1	94.4
Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	7	7	-	100.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	28	28	-	100.0

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<b>2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит</b>	Аудитын код:
2019			САГ-2020/43/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	<b>Сүүж-Уул амралт, сэргээн засах сувилал</b>		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Зочин төлөөлөгчдийн хоол хүнсний зардалд 1,239.6 мянган төгрөгийн зориулалт бус зардал гаргасан байна.	1,239.6	Зөвлөмж өгөх	Дарга, Цагдаагийн хурандаа	Ц.Батбаатар
2	Сүүж-Уул амралт, сэргээн засах сувиллын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй “УАЗ фургон 2206” маркийн автомашин 2018 оны 9 дүгээр сард галын аюулд өртөж, ажил үүрэг гүйцэтгэх боломжгүй болсон байна. Үндсэн хөрөнгийн тооллогоор тус автомашиныг бэлэн байгаа гэж тоолсон. Автомашин нь 2010 оны 3 дугаар сард ашиглалтанд орсон бөгөөд байгуулсан элэгдлээрээ анхны өртгөө нөхөж үлдэх өртөггүй болсон. Ард даатгал компаниас 8,622.0 мянган төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, автоамшиныг засварлах ажилд зориулан 20 нэр төрлийн сэлбэг худалдан авсан боловч данс бүртгэлд тусгаагүй байна.	8,622.0	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч, Дэд хурандаа	С.Отгонтөгс
<b>НИЙТ ДҮН</b>		<b>9,861.6</b>			





